



**“ТҮМЭН ШУВУУТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 04 сарын 25-ны өдөр

№ 01/2026

Улаанбаатар хот

***Компанийн жилийн үйл ажиллагааны болон
санхүүгийн тайлангийн талаархи
Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай***

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.11, 62 дугаар зүйлийн 62.1.9, “Түмэн шувуут” нээлттэй хувьцаат компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.9, 8.14 болон тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01/2026 тоот тогтоолыг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. “Түмэн шувуут” хувьцаат компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.ЭРХЭМБАЯР

“Түмэн шувуут” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлын 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн
01/2026 тоот тогтоолын хавсралт



“ТҮМЭН ШУВУУТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ДҮГНЭЛТ

“Түмэн шувуут” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлт, 2025 оны зорилтуудын гүйцэтгэлийн талаарх илтгэлийг Компанийн тухай хууль, “Түмэн шувуут” ХК-ийн дүрмийн хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн, тус компанийн Хувьцаа эзэмшигч нарт танилцуулж байна.

“Түмэн шувуут” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийг удирдах үйл ажиллагаандаа засаглалыг сайжруулах арга чиглэл, зарчмуудыг баримталж, компанийн тухай хууль, бусад дүрэм, журмыг мөрдлөг болгон тус компанийн 2025 онд хийж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зорилтыг хэлэлцэн баталж, Гүйцэтгэх удирдлагын багийг шийдвэр, зөвлөмжөөр хангаж амжилттай ажиллалаа.

Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн шийдвэр, зөвлөмжийн дагуу Гүйцэтгэх удирдлагын баг нь Компанийн засаглалын кодексын хэрэгжилтийг хангах, компанийн дотоод хяналтын тогтолцоог улам боловсронгуй болгох, эрсдэлийг бууруулах, үйл ажиллагаагаа өргөтгөх, зэрэг ажлуудыг цаг тухайд нь хийж гүйцэтгэжээ.

2025 онд Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн санхүүгийн хяналтын тогтолцоог сайжруулахын тулд улирал бүрийн санхүүгийн тайлантай танилцаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажилласан.

Компанийн засаглалын кодексын үнэлгээ нь 2025 оны эхний хагас жилд 94,4 % байсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2,8 %-иар ахисан байна. Энэ нь компанийн засаглалын хувьд холбогдох дүрэм, журмын хүрээнд сайжруулалт хийж ажилласныг харуулж байгаа төдийгүй компанийн засаглал болон үйл ажиллагааг ахиц дэвшилд хүргэхэд тодорхой нөлөө үзүүлэхүйц ажил болж чадсан гэж дүгнэж байна.

Иймд “Түмэн шувуут” ХК-ийн ТУЗ-өөс тус хувьцаат компанийн 2025 оны санхүү, үйл ажиллагаанд дараах дүгнэлтийг өгч байна.

1. “Түмэн шувуут” хувьцаат компани 2025 онд **175,0** сая ширхэг өндөг үйлдвэрлэсэн нь өмнөх оныхоос **22,3%-иар** /өмнөх онд 143,0 сая ш/өндөг /өссөн бол малын тэжээлийн үйлдвэрлэл өмнөх онтой харьцуулахад **22%-иар** нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Мөн 2025 онд **363** тн шингэн өндөг үйлдвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулахад 8%-ийн өсөлттэй байна.
2. Бүтээн байгуулалтын тухайд СХД-ийн 21 дүгээр хороо, Рашаант өртөөнд байрлалтай 3 дахь шувууны аж ахуй нь өндөглөгчийн 8 байр, дэгдээхийн 2 байрыг **барьж, ажлын байрыг 45-аар нэмсэн** нь 2025 оны үйлдвэрлэлийн тоог өсгөхөд тодорхой хувь нэмрээ оруулсан байна.
3. Үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний тоо хэмжээ өсөхөд стандартын шаардлага хангасан агуулах байр нэн тэргүүнд шаардлагатай байгааг оновчтой зохион байгуулж, 3 давхар агуулах шинээр барьсан нь өмнөх оноос 1,5 дахин их өндөг хадгалах таатай нөхцөл бүрдсэн.

4. Үйлдвэрийн тоног төхөөрөмжийг сайжруулах ажлууд хийгдэж байгаа нь ажлын бүтээмж нэмэгдэх төдийгүй ажилтны хөдөлмөрийг хөнгөвчлөхөд чухал нөлөө үзүүлж байна.
5. “Хүнсний хувьсгал” хөтөлбөрийн хүрээнд Хөдөө аж ахуйн салбарыг дэмжин Засгийн газраас олгож байгаа хөнгөлөлттэй зээлд хамрагдан бүтээн байгуулалтын ажлууд, үйлдвэрлэлийн түүхий эдийн нөөцийг бүрдүүлэлтийн асуудлыг шийдвэрлэж байгаа нь маш зөв зүйтэй ажил болсон юм.
6. “Түмэн шувуут” ХКомпани нь 2024 онд 14.4 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан бол 2025 онд 14.9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай буюу 1%-ийн өсөлттэй болж, дансны авлагын насжилт хэвийн найдваргүй авлагагүй ажилласан байна.
7. Шинээр бүтээн байгуулсан “Түмэн шувуут-3” шувууны аж ахуй нь компанийн зах зээлд эзлэх байр суурийг улам бэхжүүлэхэд эерэг нөлөө үзүүлсэн.

Цаашид авч хэрэгжүүлэх санал, зөвлөмжийн тухайд:

1. Органик бордоо, шингэн өндөг, тахианы махны үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээг нэмэгдүүлэхийн тулд холбогдох үйлдвэрлэл эрхлэгчтэй хамтран ажиллах, төрийн байгууллагын тендерт оролцох, олон нийтэд таниулах замаар эрэлтийг нэмэгдүүлэх бодлого боловсруулах
2. Борлуулалтын үр ашгийг дээшлүүлэхэд борлуулалт-маркетингийн оновчтой арга хэмжээг зөв зохион байгуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Нэгдсэн дүгнэлт:

- Тайлант хугацаанд үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээ нэмэгдсэн нь компанийн цэвэр ашиг өсөхөд нөлөөлжээ. Компанийн гүйцэтгэх удирдлагын зүгээс авч хэрэгжүүлсэн менежментийн зөв бодлого, шийдвэрийн үр дүнд компанийн үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмэгдүүлэн зах зээлд эзлэх байр сууриа улам бэхжүүлж чадсан байна.
- Импортын хамааралтай үйлдвэрлэлийн орц, барааны талаар авч хэрэгжүүлсэн зөв бодлого мөн эерэг нөлөө үзүүлжээ.
- Дотоодын өндөгний хэрэглээний 50 хувийг дангаараа нийлүүлэх боломжтой болсон
- Үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэхтэй холбоотой бүтээн байгуулалтын ажлыг богино хугацаанд хийж гүйцэтгэсэн.
- “Түмэн шувуут” ХК-ийн санхүүгийн тайлан, мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, баримт материалын бүрдэл, компанийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцүүлэн баталсан заавар, журам, аргачлал, стандартын дагуу үнэн зөв тайлагнан ажиллажээ.

Иймд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс “Түмэн шувуут” Хувьцаат компанийн гүйцэтгэх удирдлагын багийг 2025 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан гэж дүгнэж байна.

**“ТҮМЭН ШУВУУТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ**



**“ТҮМЭН ШУВУУТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 04 сарын 25-ны өдөр

№ 02/2026

Улаанбаатар хот

***Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
гишүүдийг сонгох тухай***

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.4, “Түмэн шувуут” нээлттэй хувьцаат компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.7, 8.14 болон тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04 дүгээр сарын 25-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 02/2026 тоот тогтоолыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ НЬ:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан дор дурдсан нэр дэвшигчдийг “Түмэн шувуут” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгосугай:
 1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр:
 1. Л.Эрхэмбаяр
 2. Б.Тунгалаг
 3. Ж.Болд
 4. Э.Баяржаргал
 5. А.Бакей
 6. М.Болод
 2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:
 1. Ц.Наран-Учрал
 2. Г.Мөнх-Эрдэнэ
 3. Ө.Оргил-Эрдэнэ
2. Хууль тогтоомж, компанийн дүрэм, компанийн засаглалын журмуудыг мөрдөж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нийт гишүүдэд үүрэг болгосугай.
3. ТУЗ-ын бүрэлдэхүүний талаарх олон нийтэд мэдээлж, шинээр сонгогдсон гишүүдийн мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргэхийг Гүйцэтгэх захирал (Ж.Болд)-д үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Д.Наранцэцэг/-т үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.ЭРХЭМБАЯР



**“ТҮМЭН ШУВУУТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 04 сарын 25-ны өдөр

№ 03/2026

Улаанбаатар хот

***Төлөөлөн Удирдах Зөвлөлийн цалин,
урамшууллын зардлын төсөв батлах тухай***

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, 62.1.15, “Түмэн шувуут” нээлттэй хувьцаат компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.13, 8.4.14 болон тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01/2026 тоот тогтоолыг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ** нь:

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн цалин, урамшууллын зардлын төсвийг хавсралтаар баталсугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах зардлыг санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал /Ж.Болд/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ЭРХЭМБАЯР

“Түмэн шувуут” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлын 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн
03/2026 тоот шийдвэрийн хавсралт



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН
ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХЭМЖЭЭ

ТУЗ-ийн гишүүд	Улиралд, сард / тогтмол /төг/	Нэг удаагийн хуралд оролцоогоор /төг/
Ердийн гишүүд	1,500,000	500,000
Ердийн гишүүд	1,500,000	500,000
Ердийн гишүүд	1,500,000	500,000
Ердийн гишүүд	1,500,000	500,000
Ердийн гишүүд	1,500,000	500,000
Ердийн гишүүд	1,500,000	500,000
Хараат бус гишүүд	1,500,000	500,000
Хараат бус гишүүд	1,500,000	500,000
Хараат бус гишүүд	1,500,000	500,000